

**ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧИЙН
2019 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД
ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ**

Агуулга

1. Аудитын гэрчилгээ	2
2. Аудитын тайлан.....	4
2.1. Оршил.....	4
2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага	4
2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт	4
2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин	5
2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ.....	5
2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал	5
2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар	5
2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд	6
2.9. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга.....	6
2.10. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн.....	7
2.11. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал	7
2.12. Шилэн дансны мэдээлэл	7
2.13. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт	8
2.14. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл.....	8
3. Менежментийн захидал	9
4. Аудит хийсэн санхүүгийн тайлан	11
4.1 Аудит хийсэн санхүү байдлын тайлан	11
4.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан.....	12
4.3 Аудит хийгдсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	15
4.4 Аудит хийгдсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	17
4.5 Аудит хийгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	18
4.6 Аудит хийгдсэн нэмэлт санхүүжилтийн тайлан.....	20
5. Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт	21

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт



ЭМГЭГ СУДЛАЛЫН ҮНДЭСНИЙ
ТӨВИЙН ЗАХИРАЛ Г.УЯНГА ТАНАА

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:51-26-42-30
E-mail: info@audit.gov.mn

2020.02.27 № 06/633
танай _____-ны № _____-т

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Эмгэг судлалын үндэсний төвийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

Зөрчилгүй санал дүгнэлт

Эмгэг судлалын үндэсний төвийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторов баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Эмгэг судлалын үндэсний төвийн 2019 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, программ хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.


Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

Үүрэг, хариуцлага

Төсвийн шууд захирагч нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1-д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

САНХҮҮГИЙН АУДИТЫН
ГАЗРЫН ЗАХИРАЛ БӨГӨӨД
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

2. Аудитын тайлан

2.1. Оршил

Эмгэг судлалын үндэсний төвийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг Захирал Г.Уянга Танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц асуудал, залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчил, тодруулга зэрэг аудитын үр дүн, аудитын дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэл, тайлагнал, дотоод хяналтын системийг боловсронгуй болгох чиглэлээр төсвийн зарцуулалт, үндсэн хөрөнгийн элэгдэлтэй холбоотой зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 15.2, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Эмгэг судлалын үндэсний төвийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Эмгэг судлалын үндэсний төвийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн шууд захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2019 оны 11 дүгээр сарын 20-оос 2020 оны 02 дугаар сарын 19-ний хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2020 оны 02 дугаар сарын 21-ний өдөр эцэслэн баталгаажуулж, төсвийн шууд захирагчид хүргүүлэхээр төлөвлөн Үндэсний аудитын газрын захиалгаар “Цэгцтөв богд аудит” ХХК-ийн аудитын багийн ахлагч Н.Цэрэнханд хариуцаж хэрэгжүүлэв.

Эмгэг судлалын үндэсний төвийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Үндэсний аудитын газарт 2020 оны 01 дүгээр сарын 23-ны өдрийн 30 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайлангийн аудитад баримтлах ерөнхий чиглэл, арга зүйг мөрдөн ажиллав.

Дээрх стандарт, зарчим, журамд нийцүүлж аудитын үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

Эмгэг судлалын үндэсний төвийн үйл ажиллагааны эрхэм зорилгыг “Эмгэг судлалын тусламж, үйлчилгээг үндэсний хэмжээнд чанар, хүртээмжийг байнга сайжруулж, олон улсын түвшинд хүргэхэд оршино” гэж тодорхойлсон.

Эмгэг судлалын үндэсний төвийн үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Эмчлэгдэж байгаад нас барсан тохиолдолд эмгэг судлалын задлан шинжилгээ хийж, эмчилгээ оношлогооны тохиргоог шалган баталж, клиникийн эмч нарын мэдлэг мэргэжил хариуцлагыг дээшлүүлэх;
- Онош зөрсөн ховор тохиолдолд эмгэг судлал эмнэл зүйн эмч нарын хамтарсан зөвлөгөөнийг хийж эмчилгээ үйлчилгээний доголдол, дутагдлыг шүүн хэлэлцэх;
- Орон нутгийн мэргэжил нэгт эмч нарт мэргэжил арга зүйн туслалцаа үзүүлэх;
- Өвчтөнөөс авсан амьд сорьц, эсийн түрхцэнд эд, эс химийн шинжилгээ хийх, оношлох;

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд өөрчлөлт ороогүй байна.

2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа, дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан болно.

Тус Эмгэг судлалын үндэсний төвийн мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь Сангийн яамнаас хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

Эмгэг судлалын үндэсний төв нь санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд “Dinamic” программ хангамж ашигладаг байна.

Эмгэг судлалын үндэсний төвийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд бага гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй байна.

2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Аудитаар Эмгэг судлалын үндэсний төвийн бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судлан, эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэллээ.

Аудитын төлөвлөлтийн үе шатанд 16 эрсдэлтэй асуудалд горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2018 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын дүнг сонгож, эрсдэлийн түвшинг “бага” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 2 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд сонгосон суурь үзүүлэлтийн дүн 1,628,753.7 мянган төгрөгөөс тооцон 32,575.0 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

Гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлын түвшинг 34,902.9 мянган төгрөгөөр тооцсон нь 2019 оны жилийн эцсийн санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын дүнг сонгосонтой холбоотой болно.

2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд

Эмгэг судлалын үндэсний төвийн 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 61,644.4 мянган төгрөгөөр буюу 6.1 хувиар буурсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

			/мянган төгрөг/
Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Авлага	1,004.8	-	(1,004.8)
Урьдчилгаа			-
Бараа материал	1,437.7	7,546.1	6,108.4
Үндсэн хөрөнгө	1,016,277.6	949,529.6	(66,748.0)
Нийт хөрөнгө	1,018,720.1	957,075.7	(61,644.4)
Өр төлбөр	-	-	-
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	1,018,720.1	957,075.7	(61,644.4)
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	1,018,720.1	957,075.7	(61,644.4)

Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан үндсэн хөрөнгийн данстай холбоотой байна.

Хандивын хөрөнгөөр 90,000.0 мянган төгрөгийн лабораторын тоног төхөөрөмж, ТӨБЗГ-ын шийдвэрээр, 20,000.0 мянган төгрөгийн үнэ бүхий нэг суудлын автомашин ЭМЯ-ны балансаас шилжүүлж авсан, төсөвт эд хогшил худалдан авахаар тусгагдсан 27,781.2 мянган төгрөг, нэмэлт санхүүжилтээс 6,665.4 мянган төгрөгийн эд хогшил нийт 144,446.6 мянган төгрөгөөр үндсэн хөрөнгө нэмэгдэж, ТӨБЗГ-ын 2019 оны А1/3615 тоот бичгээр 14 нэр төрлийн 20,707.1 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг акталж, устгасан байна.

2.9. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн шууд захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Монгол Улсын 2019 оны төсвийн тухай хуульд зааснаар Эмгэг судлалын үндэсний төв тайлант онд 125,500.0 мянган төгрөгийн орлого төвлөрүүлэхээр батлагдсанаас гүйцэтгэлээр 209,500.0 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлж, төлөвлөгөөг 166.9 хувиар биелүүлсэн байна.

Үндсэн болон туслах үйл ажиллагааны орлого 80,715.7 сая төгрөгөөр давсан нь дараах шалтгаантай болно. Үүнд.

- Улсын хэмжээнд умайн хүзүүний эрт илрүүлгийн шинжилгээг өрхийн эрүүл мэндийн төв, дүүргийн эрүүл мэндийн төвд хийдэг болсноор шинжилгээний тоо өссөн;
- Монгол Улсын Засгийн газраас “Элэг бүтэн Монгол үндэсний хөтөлбөрийг”-ийг баталж хэрэгжүүлж байгаатай холбогдуулан амьд сорьцын шинжилгээ өссөн;
- Иргэд, хувийн хэвшлийн байгууллагууд Эмгэг судлалын үндэсний төвийн лавлагаа, лаборатораар эд эсийн шинжилгээг хийлгүүлэн, оношийг баталгаажуулах үйлчлүүлэгчийн тоо өссөн;

Тайлант онд Төсвийн шууд захирагчийн хэрэгжүүлэх хөтөлбөрт зориулан 1,429,593.9 мянган төгрөгийг урсгал зардалд зарцуулахаар батлагджээ.

Нийт зардлын 1,429,593.9 мянган төгрөгөөс улсын төсвөөс 1,304,093.9 мянган төгрөг, үндсэн болон туслах үйл ажиллагааны орлогоос 125,500.0 мянган төгрөг санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 4.5-д харуулав.

Улсын төсвийн санхүүжилт 1304,093.9 мянган төгрөгийн төсвөөс 1,197,495.6 мянган төгрөгийг зарцуулж 106,598.3 мянган төгрөгийг буцаан төвлөрүүлсэн нь орон тоо дутуу ажилласан цалингийн зардал 90,644.2 мянган төгрөг, бусад зардлын 12,673.5 мянган төгрөгийн зарцуулаагүй үлдэгдэлтэй холбоотой байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 1,326,280.1 мянган төгрөг буюу 92.8 хувьтай байгаа нь Эмгэг судлаач, эс судлаач эмч нарын орон тоонд ажиллах эмчийн хүрэлцээгүй байдлаас батлагдсан орон тоо дутуу ажиллаж цалингийн зардал хэмнэгдсэнээс шалтгаалсан байна.

Нэмэлт төсөв: Хандив тусламжаар Дэлхийн эрүүл мэндийн байгууллагаас 6,500.0 мянган төгрөг, Эрүүл мэндийг дэмжих сангаас 18,380.4 мянган төгрөг, Эрүүл мэндийн хөгжлийн төвөөс 25,738.5 мянган төгрөг үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлогоос 81,399.7 мянган төгрөг нийт 132,018.6 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлжээ.

Үүнээс: Эмгэг судлаач, эс судлаач эмч нарын сургагч багш нарын цалин нийгмийн даатгалын шимтгэлд 4,674.4 мянган, бусад урсгал зардалд 84.0 мянган, тэтгэмж урамшуулалд 43,337.8 мянган нийт 132,016.2 мянган төгрөгийг зарцуулж, үлдэгдэл 2.4 мянган төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлсэн байна.

2.10. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон 16 эрсдэл, гүйцэтгэх үе шатанд 18 эрсдэл тодорхойлж нийт 51 горим сорил хэрэгжүүллээ.

Аудитаар дараах 31,045.1 мянган төгрөгийн залруулагдаагүй алдаа, зөрчил илэрснээс 30,746.9 мянга төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоож, албан шаардлага хүргүүллээ. Үүнд:

1. Эд хариуцагчид эд хөрөнгийн хариуцлагын нэмэгдэл хөлс 321.0 мянган төгрөг олгосон нь Хөдөлмөрийн тухай хуулийн 50 дугаар зүйлийн 50.2 дахь заалттай нийцэхгүй, санхүүгийн тайлангийн үнэн зөв байдал, батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь:

Хавсран ажилласны нэмэгдэл хөлсийг үндэслэлгүй олгосныг төлүүлэн төсөвт төвлөрүүлэхээр төлбөрийн акт тогтоох

2. Ажлын үр дүнгийн урамшуулал 30,425.9 мянган төгрөг жилийн эцэст давхардуулан олгосон нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 дэх заалттай нийцэхгүй, санхүүгийн тайлангийн үнэн зөв байдал батламж мэдэгдэл хангагдахгүй байна.

Шийдвэрлэсэн нь:

Үр дүнгийн урамшууллыг давхардуулан олгохыг таслан зогсоох албан шаардлага өгсөн

Аудитаар илэрсэн 298.2 мянган төгрөгийн алдаа, зөрчилд 3 зөвлөмж өгч, менежментийн захидалд тусгалаа.

2.11. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал

Эрүүл мэндийн яамны балансаас Nissan patrol маркийн, 4169-8 цилиндрийн багтаамжтай УНЧ 07-35 улсын дугаар бүхий 2005 онд ашиглалтад орж 15 жил ашиглагдсан, 20,000.0 сая төгрөгийн балансын үнэтэй автомашин шилжүүлсэн нь цаашид ашиглах хугацаа, элэгдлээрээ өртгөө нөхөж чадах эсэх нь тодорхойгүй байгааг анхааран авч үзэх нь зүйтэй гэж үзлээ.

2.12. Шилэн дансны мэдээлэл

Эмгэг судлалын үндэсний төв Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан 18 мэдээллийг хугацаанд нь байршуулсан байна. Хугацаа хоцроож мэдээлсэн болон байршуулаагүй мэдээлэл байхгүй.

2.13. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн 13,539.7 мянган төгрөгийн зөрчилд 10,110.5 мянган төгрөгийн төлбөрийн акт тогтоосныг барагдуулан, зөрчлийг арилгах 1 албан шаардлага хүргүүлснийг хэрэгжүүлсэн байна.

Нийт 4 зөвлөмж өгснөөс 3 зөвлөмжийг хэрэгжүүлж, 1 зөвлөмж хэрэгжих шатанд, зөвлөмжийн хэрэгжилт 75.0 хувьтай байна.

2.14. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид Эмгэг судлалын үндэсний төвийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

Эмгэг судлалын үндэсний төвийн 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлт болон бусад илчлэл тодруулгыг холбогдох хууль, УСНББОУС-ын дагуу материаллаг байдлын хувьд үнэн зөв, бодитой илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

3. Менежментийн захидал

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга аудитын үр дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

1. Балансын данстай холбоотой асуудал

1.1.1 Илрүүлэлт:

Илүү цагийн хөлс тооцож олгохдоо “Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчид нэмэгдэл хөлс олгох журам”-д заасан илүү цагаар ажиллуулсан шалтгааныг тогтоох маягыг хөтлөөгүй нь Засгийн газрын 2018 оны 382 дугаар тогтоолын 2-т “Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчид нэмэгдэл хөлс олгох журам”-ын 2 дахь даалтыг хэрэгжүүлээгүй, санхүүгийн тайлангийн иж бүрэн байх батламж мэдэгдэлтэй нийцэхгүй байна.

1.1.2 Эрсдэл:

Анхан шатны баримтын бүрдэл хангагдахгүй байх, үнэн зөв байдал батламж мэдэгдэл хангагдахгүй байх

1.1.3 Өгсөн зөвлөмж:

Засгийн газрын 2018 оны 12 дугаар сарын 19-ний өдрийн "Журам батлах тухай" 382 дугаар тогтоолоор батлагдсан Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчид нэмэгдэл хөлс олгох хавсралтын "Нэмэгдэл хөлс тооцож олгох хуудас"-аар нэмэгдэл хөлсийг тооцож олгож байх.

1.1.4 Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

Нэмэгдэл хөлс тооцож олгох хуудсыг үйл ажиллагаандаа мөрдөж ажиллана.

1.2.1 Илрүүлэлт:

Элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн боловч ашиглагдаж байгаа үндсэн хөрөнгөнд дахин үнэлгээ хийх эсэх асуудлыг шийдвэрлээгүй байгаа нь УСНББОУС-17-ийн 55-д "...хөрөнгийн үнэ цэнэ нь түүний дансны үнээс илүү байх тохиолдолд ч элэгдлийн шимтгэлийг байгуулна", Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолын 7.1-д “Төрийн өмчийн хуулийн этгээд нь эзэмшилдээ байгаа илүүдэл эд хөрөнгө болон элэгдэл хорогдлын шимтгэлээр анхны үнийг нөхсөн, түүнчлэн нөхөөгүй боловч гэмтэж, засаж сэлбээд өөр зориулалтаар ашиглаж болох эд хөрөнгийн ашиглалтын хугацаа болон үнийг шинэчлэн тогтоох саналыг бэлтгэн Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлж шийдвэрлүүлнэ” гэж заасантай нийцэхгүй байна.

1.2.2 Эрсдэл:

Үлдэх өртөггүй хөрөнгө ашиглах нь санхүүгийн тайлан буруу илэрхийлэгдэх. санхүүгийн тайлангийн тодруулга толилуулга, үнэн зөв байх батламж мэдэгдэлтэй нийцэхгүй байх.

1.2.3 Өгсөн зөвлөмж:

Үлдэх өртөггүй ашиглагдаж байгаа үндсэн хөрөнгийг цаашид ашиглах бол ашиглалтын хугацаа болон үнийг шинэчлэн тогтоох санал боловсруулж шийдвэрлүүлэх

1.2.4 Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

Шийдвэрлүүлэхээр зохих байгууллагад явуулсан шийдвэр гарахаар зохицуулна.

2. Дотоод хяналттай холбоотой асуудал

2.1.1 Илрүүлэлт:

Хангамж бараа материалын зардал, нормативт зардлын төсөв бүлгийн дүнгээр хэтэрсэн нь Сангийн сайдын 2014 оны 55 дугаар тушаалаар батлагдсан “Эдийн засгийн ангилал”-ыг хэрэгжүүлээгүй, санхүүгийн тайлангийн үнэлгээ, хэмжилт батламж мэдэгдэлд нийцэхгүй байна.

2.1.2 Эрсдэл:

Төсвийн тухай хуулиар батлагдсан төсөв хэтрэх

2.1.3 Өгсөн зөвлөмж:

Батлагдсан төсвийн эдийн засгийн ангиллыг бүртгэлд тусгахдаа зардлын бүлгийг зөв бичиж бүлэг хооронд шилжүүлэн зарцуулахгүй байх.

2.1.3 Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

Цаашид зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллана.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2020 оны 06 дугаар сарын 10-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

4. Аудит хийсэн санхүүгийн тайлан

4.1 Аудит хийсэн санхүү байдлын тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	/Төгрөгөөр/	
		Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>2,442,568.76</u>	<u>7,546,129.38</u>
33	АВЛАГА	1,004,824.00	-
335	Бусад авлага	1,004,824.00	-
3351	Байгууллагаас авах авлага	408,798.00	-
3352	Хувь хүмүүсээс авах авлага	596,026.00	-
35	БАРАА МАТЕРИАЛ	1,437,744.76	7,546,129.38
351	Түүхий эд материал	218,500.00	6,820,000.00
35110	Тусгай зориулалттай материал	218,500.00	6,820,000.00
354	Хангамжийн материал	1,219,244.76	726,129.38
35410	Бичиг хэргийн материал	8,512.50	-
35420	Аж ахуйн материал	162,640.00	-
35440	Түлш, шатах тослох материал	1,048,092.26	726,129.38
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>1,016,277,591.01</u>	<u>949,529,638.80</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	1,016,277,591.01	949,529,638.80
392	Биет хөрөнгө	1,016,181,479.97	948,493,805.45
39201	Барилга, байгууламж, орон сууц	584,190,200.00	584,190,200.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	-	(16,227,505.56)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	35,207,000.00	55,207,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(35,207,000.00)	(36,040,333.33)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	939,130,257.80	1,032,076,896.80
39206	Хуримтлагдсан элэгдэл	(541,336,504.49)	(710,288,522.71)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	60,164,440.00	71,027,350.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	(25,966,913.34)	(31,451,279.75)
393	Биет бус хөрөнгө	96,111.04	1,035,833.35
39301	Програм хангамж	1,200,000.00	1,130,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(1,103,888.96)	(94,166.65)
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>1,018,720,159.77</u>	<u>957,075,768.18</u>
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>1,018,720,159.77</u>	<u>957,075,768.18</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	1,018,720,159.77	957,075,768.18
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	368,401,756.70	368,401,756.70
512	Хуримтлагдсан үр дүн	385,961,492.92	324,317,101.33
51210	Өмнөх үеийн үр дүн	503,915,235.48	385,961,492.92
51220	Тайлант үеийн үр дүн	(117,953,742.56)	(61,644,391.59)
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	264,356,910.15	264,356,910.15
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>1,018,720,159.77</u>	<u>957,075,768.18</u>

4.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Тайлант хугацаа : 2019 оны 12 дугаар сарын 31-ний дуусгавар болсон тайлан

/Төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	1,510,799,938.29	1,683,503,604.34
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	193,088,150.29	328,106,804.34
120	Нийтлэг татварын бус орлого	193,088,150.29	328,106,804.34
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	191,544,792.00	328,106,804.34
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	191,423,300.00	209,500,200.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	121,492.00	118,606,604.34
120009	Бусад орлого	1,543,358.29	-
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,317,711,788.00	1,355,396,800.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	1,279,814,788.00	1,304,093,900.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,225,982,200.00	1,304,093,900.00
131005	Хөрөнгийн санхүүжилт	53,832,588.00	-
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	37,897,000.00	51,302,900.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	12,002,000.00	6,500,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	25,895,000.00	44,178,900.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	-	624,000.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	1,628,753,630.85	1,745,122,218.09
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,628,753,630.85	1,745,122,218.09
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,436,548,930.82	1,593,948,084.17
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	795,219,311.15	875,398,278.95
210101	Үндсэн цалин	461,896,812.96	688,865,076.95
210102	Нэмэгдэл	333,322,498.19	68,316,880.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	-	118,216,322.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	101,018,358.85	118,578,823.41
210201	Тэтгэврийн даатгал	86,012,937.85	76,376,101.41
210202	Тэтгэмжийн даатгал	-	8,872,197.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	-	16,071,800.00
210204	Ажилгүйдлийн даатгал	-	1,562,090.00
210205	Эрүүл мэндийн даатгал	15,005,421.00	15,696,635.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	37,130,400.00	51,351,000.00
210301	Гэрэл, цахилгаан	10,116,907.00	25,087,807.00
210302	Түлш, халаалт	11,056,734.00	12,182,700.00

210303	Цэвэр, бохир ус	15,156,759.00	13,780,493.00
210304	Байрны түрээс	800,000.00	300,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	52,726,336.30	26,911,283.00
210401	Бичиг хэрэг	11,702,370.00	4,392,862.50
210402	Тээвэр, шатахуун	5,097,761.00	6,036,607.22
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,427,678.30	1,445,963.28
210404	Ном, хэвлэл	246,700.00	-
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал	7,460,650.00	6,762,390.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	24,791,177.00	8,273,460.00
2105	Нормативт зардал	203,105,870.00	222,720,918.19
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	191,201,215.00	213,160,909.19
210502	Хоол, хүнс	3,999,955.00	1,872,790.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	7,904,700.00	7,687,219.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	2,859,489.00	14,436,220.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	-	4,389,400.00
210604	Урсгал засвар	2,859,489.00	10,046,820.00
2107	Томилолт, зочны зардал	6,058,900.00	22,580,200.00
210701	Гадаад албан томилолт	-	8,393,400.00
210702	Дотоод албан томилолт	6,058,900.00	14,186,800.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	19,491,919.98	24,317,120.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	9,600,000.00	9,600,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	4,000,000.00	10,906,500.00
210803	Даатгалын үйлчилгээ	989,000.00	414,920.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	158,400.00	74,500.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	39,600.00	39,600.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	3,098,000.00	3,281,600.00
210807	Газрын төлбөр	1,027,219.98	-
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	34,500.00	-
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	545,200.00	-
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	218,938,345.54	237,654,240.62
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	11,862,140.00	26,485,417.25
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	207,076,205.54	211,168,823.37
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	192,204,700.03	151,174,133.92
2132	Бусад урсгал шилжүүлэг	167,086,128.04	44,573,527.50
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	115,301,433.00	-
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	51,784,695.04	44,573,527.50
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	-	106,600,606.42
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	106,600,606.42

2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	25,118,571.99	-
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	25,118,571.99	-
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	<u>(117,953,692.56)</u>	<u>(61,618,613.75)</u>
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	-	25,777.84
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	-	25,777.84
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	-	(25,777.84)
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	<u>(117,953,692.56)</u>	<u>(61,644,391.59)</u>

4.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Тайлант хугацаа : 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлан

/Төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	1,455,302,500.00	1,564,897,000.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	191,423,300.00	209,500,200.00
120	Нийтлэг татварын бус орлого	191,423,300.00	209,500,200.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	191,423,300.00	209,500,200.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	191,423,300.00	209,500,200.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,263,879,200.00	1,355,396,800.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	1,225,982,200.00	1,304,093,900.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,225,982,200.00	1,304,093,900.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	37,897,000.00	51,302,900.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	12,002,000.00	6,500,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	25,895,000.00	44,178,900.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	-	624,000.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	1,418,841,700.04	1,530,450,351.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,418,841,700.04	1,530,450,351.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,226,573,800.01	1,379,212,335.08
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	793,123,377.29	874,447,387.95
210101	Үндсэн цалин	500,273,701.76	579,426,990.79
210102	Нэмэгдэл	292,849,675.53	156,743,644.16
210103	Унаа хоолны хөнгөлөлт	-	80,850,000.00
210104	Урамшуулал	-	57,426,753.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	100,404,008.42	118,373,336.41
210201	Тэтгэврийн даатгал	100,404,008.42	75,688,265.94
210202	Тэтгэмжийн даатгал	-	9,610,600.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	-	15,290,478.00
210204	Ажилгүйдлийн даатгал	-	1,545,000.00
210205	Эрүүл мэндийн даатгал	-	16,238,992.47
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	37,130,400.00	51,351,000.00
210301	Гэрэл, цахилгаан	8,918,700.00	32,744,500.00
210302	Түлш, халаалт	12,182,700.00	12,182,700.00
210303	Цэвэр, бохир ус	15,229,000.00	6,123,800.00
210304	Байрны түрээс	800,000.00	300,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	50,813,359.30	24,564,403.28
210401	Бичиг хэрэг	11,401,080.00	5,925,100.00
210402	Тээвэр, шатахуун	5,757,600.00	5,597,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	4,067,578.30	1,897,563.28
210404	Ном, хэвлэл	249,400.00	-
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	7,234,000.00	9,735,100.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	-	1,409,640.00
210407	Аж ахуйн материал худалдан авах зардал	22,103,701.00	-
2105	Нормативт зардал	203,368,755.00	221,004,369.19
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	191,427,500.00	211,130,075.86
210502	Хоол, хүнс	3,999,955.00	2,033,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	7,941,300.00	7,841,293.33
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	3,767,700.00	14,964,849.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	-	4,208,050.00
210604	Урсгал засвар	3,767,700.00	10,756,799.00

2107	Томилолт, зочны зардал	4,618,900.00	22,591,240.00
210701	Гадаад албан томилолт	-	8,393,400.00
210702	Дотоод албан томилолт	4,618,900.00	14,197,840.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	18,909,500.00	25,633,520.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	9,600,000.00	9,600,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	4,000,000.00	10,906,500.00
210803	Даатгалын үйлчилгээ	989,000.00	414,920.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	158,400.00	74,500.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	39,600.00	39,600.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	3,098,000.00	3,098,000.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээ хураамж	34,500.00	-
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	990,000.00	1,500,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	14,437,800.00	26,282,229.25
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	14,437,800.00	26,282,229.25
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	192,267,900.03	151,238,015.92
2132	Бусад урсгал шилжүүлэг	167,149,328.04	44,637,409.50
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	125,369,983.00	-
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	41,779,345.04	44,637,409.50
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	25,118,571.99	106,600,606.42
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	25,118,571.99	106,600,606.42
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	<u>36,460,799.96</u>	<u>34,446,649.00</u>
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	36,480,600.00	34,446,649.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	36,480,600.00	34,446,649.00
2200	Дотоод эх үүсвэрээр	36,480,600.00	34,446,649.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	36,480,600.00	34,446,649.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	<u>(36,480,600.00)</u>	<u>(34,446,649.00)</u>
7	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	<u>=</u>	<u>=</u>
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	(19,800.04)	-
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	19,800.04	-
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		

4.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Тайлант хугацаа : 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлан

/Төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2017 оны 12 дугаар сарын 31-ний үлдэгдэл	368,401,756.70	0.00	503,915,235.48	872,316,992.18
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.00	0.00	0.00	0.00
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	368,401,756.70	0.00	503,915,235.48	872,316,992.18
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	0.00	0.00	0.00	0.00
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	0.00	264,356,910.15	0.00	264,356,910.15
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	0.00	0.00	0.00	0.00
C07	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	-117,953,742.56	-117,953,742.56
C08	2018 оны 12 дугаар сарын 31-ний үлдэгдэл	368,401,756.70	264,356,910.15	385,961,492.92	1,018,720,159.77
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.00	0.00	0.00	0.00
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	368,401,756.70	264,356,910.15	385,961,492.92	1,018,720,159.77
D08	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	-61,644,391.59	-61,644,391.59
D09	2019 оны 12 дугаар сарын 31-ний үлдэгдэл	368,401,756.70	264,356,910.15	324,317,101.33	957,075,768.18

4.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

Дансны код	Үзүүлэлт	Тайлант оны		Зөрүү	Хувь
		Төлөвлөгөө	Гүйцэтгэл		
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,429,593,900.00	1,326,280,158.83	103,313,741.17	92.77
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,429,593,900.00	1,326,280,158.83	103,313,741.17	92.77
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,428,293,900.00	1,324,980,558.83	103,313,341.17	92.77
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	961,055,200.00	870,390,979.95	90,664,220.05	90.57
210101	Үндсэн цалин	608,917,000.00	575,370,582.79	33,546,417.21	43.38
210102	Нэмэгдэл	210,396,500.00	156,743,644.16	53,652,855.84	11.82
210103	Унаа хоолны хөнгөлөлт	80,850,000.00	80,850,000.00	-	100.00
210104	Урамшуулал	60,891,700.00	57,426,753.00	3,464,947.00	4.33
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	129,742,500.00	117,755,248.41	11,987,251.59	8.88
210201	Тэтгэврийн даатгал	81,689,700.00	75,070,177.94	6,619,522.06	5.66
210202	Тэтгэмжийн даатгал	9,610,600.00	9,610,600.00	-	100.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	17,299,000.00	15,290,478.00	2,008,522.00	88.39
210204	Ажилгүйдлийн даатгал	1,922,100.00	1,545,000.00	377,100.00	80.38
210205	Эрүүл мэндийн даатгал	19,221,100.00	16,238,992.47	2,982,107.53	84.49
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	51,051,000.00	51,051,000.00	-	100.00
210301	Гэрэл, цахилгаан	32,744,500.00	32,744,500.00	-	100.00
210302	Түлш, халаалт	12,182,700.00	12,182,700.00	-	100.00
210303	Цэвэр, бохир ус	6,123,800.00	6,123,800.00	-	100.00
2104	Хангамж, бараа материалын зардал	19,608,200.00	19,608,163.28	36.72	100.00
210401	Бичиг хэрэг	2,837,500.00	2,837,500.00	-	100.00
210402	Тээвэр, шатахуун	5,597,000.00	5,597,000.00	-	100.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,438,600.00	1,438,563.28	36.72	100.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	9,735,100.00	9,735,100.00	-	100.00
2105	Нормативт зардал	210,368,800.00	210,366,849.19	1,950.81	100.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	205,427,500.00	205,425,555.86	1,944.14	100.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	4,941,300.00	4,941,293.33	6.67	100.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	28,048,900.00	28,046,998.00	1,902.00	99.99
210601	Багаж, техник, хэрэгсэл	17,781,200.00	17,781,200.00	-	100.00
210602	Тавилга	6,500,000.00	6,500,000.00	-	100.00
	Урсгал засвар	3,767,700.00	3,765,798.00	1,902.00	0.28
2107	Томилолт, зочны зардал	2,362,900.00	2,362,900.00	-	100.00
210702	Дотоод албан томилолт	2,362,900.00	2,362,900.00	-	100.00
	Хичээл үйлдвэрлэл хийх зардал	3,500,000.00	3,500,000.00	-	0.26
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	22,556,400.00	21,989,420.00	657,980.00	1.65
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил	13,100,000.00	13,100,000.00	-	100.00

	үйлчилгээний төлбөр хураамж				
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	6,041,400.00	6,041,400.00	-	100.00
210803	Даатгалын үйлчилгээ	989,000.00	414,920.00	574,080.00	41.95
210804	Тээврийн хэрэгслийн татвар	158,400.00	74,500.00	83,900.00	47.03
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	39,600.00	39,600.00	-	100.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	4,228,000.00	4,228,000.00	-	100.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	1,500,000.00	1,500,000.00	-	100.00
	Харуул хамгаалалтын зардал	9,600,000.00	9,600,000.00	-	0.72
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,300,000.00	1,299,600.00	400.00	99.97
2132	Бусад урсгал шилжүүлэг	1,300,000.00	1,299,600.00	400.00	99.97
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,300,000.00	1,299,600.00	400.00	99.97
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	1,429,593,900.00	1,326,280,158.83	103,313,741.17	100.00
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	1,304,093,900.00	1,197,495,658.83	106,598,241.17	90.29
131001	Улсын төсвөөс санхүүжих	1,304,093,900.00	1,197,495,658.83	106,598,241.17	92.08
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	125,500,000.00	128,784,500.00	(3,284,500.00)	102.62
120004	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	125,500,000.00	128,784,500.00	(3,284,500.00)	102.62
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	70	65	5	92.86
620001	Удирдах ажилтан	1	1	-	100.00
620002	Гүйцэтгэх ажилтан	52	54	(2)	103.85
620003	Үйлчлэх ажилтан	17	10	7	58.82

4.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр /

Дансны код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН		132,018,600.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ		132,018,600.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ		88,678,425.25
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил		4,056,408.00
210101	Үндсэн цалин		4,056,408.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл		618,088.00
210201	Тэтгэврийн даатгал		618,088.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал		300,000.00
210304	Байрны түрээс		300,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал		4,956,240.00
210401	Бичиг хэрэг		3,087,600.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр		459,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс		1,409,640.00
2105	Нормативт зардал		12,220,520.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл		7,287,520.00
210502	Хоол, хүнс		2,033,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл		2,900,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал		15,151,500.00
210601	Багаж, техник, хэрэгсэл		7,132,500.00
210602	Тавилга		940,000.00
210604	Урсгал засвар		7,079,000.00
2107	Томилолт, зочны зардал		20,228,340.00
210701	Гадаад албан томилолт		8,393,400.00
210702	Дотоод албан томилолт		11,834,940.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж		4,865,100.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох		4,865,100.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал		26,282,229.25
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх		26,282,229.25
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ		43,340,174.75
213102	Засгийн газрын гадаад шилжүүлэг		-
2132	Бусад урсгал шилжүүлэг		43,337,809.50
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал		43,337,809.50
2133	Олгосон санхүүжилт, шилжүүлэг		2,365.25
213303	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, төвлөрүүлэх шилжүүлэг		2,365.25
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР		132,018,600.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого		132,018,600.00
131102	Төсвийн жилийн явцад УИХ-аас соёрхон баталсан, ЗГ хоорондын гэрээ болон ОУ байгууллагаас авах хөнгөлөлттэй зээл		6,500,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө		44,178,900.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого		81,339,700.00
IV	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)		-
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		

5. Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

2020.02.14	Аудитын нэр:	Эмгэг судлалын төвийн 2019 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудит	Аудитын код:
Огноо:			САГ-2020-/136/-СТА-ТШЗ
Шалгагдсан байгууллагын нэр:	Эмгэг судлалын үндэсний төв		Мянган төгрөгөөр

№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
			Нэр	Албан тушаал	Овог нэр
	1	2	3	4	5
1	Элэгдлээрээ анхны өртгөө нөхөж үлдэх өртөггүй болсон үндсэн хөрөнгийг ашиглаж байна.	-	Зөвлөмж өгсөн	Захирал Ерөнхий нягтлан бодогч	Г.Уянга М.Саранцэцэг
2	Нярав Ж.Оюун-Эрдэнэд эд хариуцагчийн нэмэгдэл хөрөнгийн бүрэн хариуцлагын гэрээг хавсран ажилласан 10 хувь гэж хавсран ажилласны нэмэгдэл хөлс олгосон	321.0	Төлбөрийн акт тогтоосон	Захирал Ерөнхий нягтлан бодогч	Г.Уянга М.Саранцэцэг
3	Хангамж, бараа материалын материалын зардал, нормативт зардлын бүлэг хэтэрсэн	298.2	Зөвлөмж өгсөн	Захирал Ерөнхий нягтлан бодогч	Г.Уянга М.Саранцэцэг
4	Илүү цагийн нэмэгдэл хөлс олгох үндэслэл, ажлын товч агуулгыг тодорхойлсон маягыг хөтлөөгүй.	-	Зөвлөмж өгсөн	Захирал Ерөнхий нягтлан бодогч	Г.Уянга М.Саранцэцэг
5	Улирлын үр дүнгийн урамшууллыг жилийн эцэст давхардуулан олгосон	30,425.9	Албан шаардлага өгсөн	Захирал Ерөнхий нягтлан бодогч	Г.Уянга М.Саранцэцэг
	ДҮН	31,045.1			



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР АКТ

2020 оны 03 дугаар сарын 03 № 02/44
САГ-2020/136/СТА-тмз

Улаанбаатар хот

Төсөвт төвлөрүүлэх тухай

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2-т заасан Үндэсний аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасан цаглабарт хугацааны дагуу Эмгэг судлалын үндэсний төвийн 2019 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Нярав Ж.Оюун-Эрдэнэ-д батлагдсан орон тоогүй байхад, эд хөрөнгө хариуцан ажилласны төлөө хавсран ажилласан нэмэгдэл хөлс 321,004.00 төгрөг олгосон.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.2-т "батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих", мөн хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.3-т "төсвийн гүйцэтгэлийг хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлж, тайлагнах" гэж заасныг тус тус зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.12-т "аудитын явцад илэрсэн төлбөр, зөрчлийг барагдуулах акт тавих, "Төрийн аудитын байгууллагын акт тогтоох, албан шаардлага өгөхөд баримтлах журам"-ын 3.1-т заасныг үндэслэн **ТОГТООХ нь:**

1. Хавсран ажилласны нэмэгдэл хөлс илүү олгосон 321,004.00 төгрөгийг Үндэсний аудитын газрын Төрийн сангийн 100900000601 тоот дансанд төвлөрүүлэх,
2. Актын биелэлтийг 2019 оны 07 дугаар сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг Эмгэг судлалын үндэсний төвийн захирал Г.Уянга, Ерөнхий нягтлан бодогч М.Саранцэцэг нарт хариуцуулав.

АКТ

ТОГТООСОН:

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ БӨГӨӨД ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
Ц.НАРАНЧИМЭГ
АУДИТОР Ц.ЦЭРЭНХҮҮ
ГЭРЭЭГЭЭР ГҮЙЦЭТГЭГЧ:
ЦЭГЦТӨВ БОГД АУДИТ ХХК-ИЙН
ЗАХИРАЛ Н.ЦЭРЭНХАНД

ЗӨВШӨӨРСӨН:

ЭМГЭГ СУДЛАЛЫН ҮНДЭСНИЙ
ТӨВИЙН ЗАХИРАЛ

Г.УЯНГА

ЕРӨНХИЙ НЯГТЛАН БОДОГЧ

М.САРАНЦЭЦЭГ

Акт, албан шаардлагын биелэлт хангагдаагүй тохиолдолд Төрийн аудитын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.2.2-д "Төрийн аудитын байгууллагаас тавьсан албан шаардлага, төлбөрийн актыг цаг хугацаанд нь биелүүлээгүй тохиолдолд зөрчил гаргасан албан тушаалтныг үүрэгт ажлаас нь халах тухай саналыг төрийн аудитын байгууллага эрх бүхий албан тушаалтанд хүргүүлнэ" гэж заасны дагуу хариуцагч албан тушаалтанд хариуцлага тооцуулахаар эрх бүхий албан тушаалтанд санал хүргүүлнэ.

\\10.10.10.20\Bichig_Khereg\Akt\2020\0303SAG3.Docx

001090067



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2020 оны 03 дугаар сарын 03

№ 02/74

Улаанбаатар хот

СТГ- 2020/136/СТГ- тш3

Зөрчил арилгуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1-т заасан Үндэсний аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд Төсвийн тухай хуулийн 8.9.1-д заасан цаглабарт хугацаанд “Эмгэг судлалын үндэсний төв”-ийн 2019 оны жилийн эцсийн Санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Ажиллагсдад улирлын үр дүнгийн урамшууллыг давхардуулан олгосон байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 5 дугаар тогтоолын 3 дугаар хавсралтаар баталсан Төрийн албан хаагчид мөнгөн урамшуулал олгох журмын 2.2-т “Төрийн албан хаагчид улирлын ажлын үр дүнгээр олгох мөнгөн урамшууллын дээд хэмжээ нь албан хаагчийн албан тушаалын сарын үндсэн цалингийн 40 хувиас хэтрэхгүй байна” гэж заасныг зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.12-т “аудитын явцад илэрсэн төлбөр, зөрчлийг барагдуулах албан шаардлага өгөх”, “Төрийн аудитын байгууллагын акт тогтоох, албан шаардлага өгөхөд баримтлах журам”-ын 4.1-т заасныг үндэслэн **ШААРДАХ** нь:

1. Үр дүнгийн урамшуулал олгох журмыг баримтлан ажиллаж, давхардуулан олгосон зөрчлийг дахин давтан гаргахгүй байх,
2. Албан шаардлагын биелэлтийг 2019 оны 06 дугаар сарын 10-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг Эмгэг судлалын үндэсний төвийн захирал Г.Уянга, Ерөнхий нягтлан бодогч М.Саранцэцэг нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГЫГ

ТОГТООСОН:

САГ-ЫН ЗАХИРАЛ БӨГӨӨД
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Ц.НАРАНЧИМЭГ

АУДИТОР Ц.ЦЭРЭНХҮҮ

“ЦЭГЦТӨВ БОГД АУДИТ” ХХК-ИЙН
ЗАХИРАЛ Н.ЦЭРЭНХАНД

ЗӨВШӨӨРСӨН:

“ЭМГЭГ СУДЛАЛЫН ҮНДЭСНИЙ
ТӨВ”-ИЙН ЗАХИРАЛ

Г.УЯНГА

ЕРӨНХИЙ НЯГТЛАН БОДОГЧ

М.САРАНЦЭЦЭГ

Акт, албан шаардлагын биелэлт хангагдаагүй тохиолдолд Төрийн аудитын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.2.2-д “Төрийн аудитын байгууллагаас тавьсан албан шаардлага, төлбөрийн актыг цаг хугацаанд нь биелүүлээгүй тохиолдолд зөрчил гаргасан албан тушаалтныг үүрэгт ажлаас нь улаах тухай саналыг төрийн аудитын байгууллага эрх бүхий албан тушаалтанд хүргүүлнэ” гэж заасны дагуу хариуцагч албан тушаалтанд хариуцлага тооцуулахаар эрх бүхий албан тушаалтанд санал хүргүүлнэ.

\\10.10.10.Richie_Kherep\Alban Shaardlaga\2020\03\03\AG16.Docx

001080236